



Jamieson™
NATURAL SOURCES | SINCE 1922

**БҮТЭЭГДЭХҮҮНИЙ
ТАНИЛЦУУЛГА**



**ГЭР БҮЛИЙН
ГИШҮҮН БҮРД**



1922 онд Канад улсад үүсгэн байгуулагдсан Jamieson Wellness Inc Corporate / 9 компани Jamieson Laboratories Ltd. Дэлхийн 45 гаруй улсад албан ёсны дистрибьютер эрхтэй. Гэр бүлийн гишүүн бүрд зориулагдсан байгалийн гаралтай биологийн идэвхт бүтээгдэхүүний хамгийн том брэнд.



360 Pure амлалт нь Jamieson брэндийг бусдаас ялгаруулдаг бөгөөд таны итгэж болох аюулгүй, цэвэр, үр дүнтэй бүтээгдэхүүний бэлэг тэмдэг юм.



Бүтээгдэхүүний шошго дээрх туулайгаар дүрслэгдсэн **“АМЬТАНД ТУРШИЛТ ХИЙХГҮЙ”** гэсэн тэмдэг нь бид ямар ч хүнсний нэмэлт бүтээгдэхүүнийг амьтан дээр туршихгүй гэсэн амлалтыг илэрхийлнэ.



Шошго дээр заасан ургамлын төрөл зүйл, бактерийн омгийн үнэн зөвийг баталгаажуулахын тулд ДНХ хамгийн сүүлийн үеийн технологи ашиглаж буй үйлдвэрлэгчээс үл хамааралтай Их Сургуульд суурилсан баталгаажуулалтын хөтөлбөр юм. Тухайн бүтээгдэхүүний үндсэн үйлчлэгч бодисын эсийн ДНХ шинжилгээг гуравдагч тал болох Канад улсын Гвельфагийн Их Сургуулиас шалган баталгаажуулдаг.

essenti  **Is** ^{TM/ MC}

“Essentials™” тэмдэг нь эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн эрүүл мэндийн үндэс суурь гэж зөвлөдөг бүтээгдэхүүн дээр дардаг тэмдэг юм.

PROBIOTIC 10 BILLION №60 КАПСУЛ

Ходоод гэдэсний замын бичил орчныг хэвийн болгох, үйл ажиллагааг нь сайжруулах, дархлааны системийн үйл ажиллагааг зүгшрүүлэхэд тусална. Эмгэг тээгч бактерийг дарангуйлж, бодисын солилцоог сайжруулж, дархлааг дэмжинэ.

НАЙРЛАГА: 1 капсулд

- » *Probiotic complex- 10 Billion complex*
- » *Bifidobacterium animalis subsp. Lactis (UABla-12) - 2.0B CFU*
- » *Lactobacillus paracasei (UALpc-04) - 1.5B CFU*
- » *Lactobacillus breve (UABbr-11) - 1.0 CFU*
- » *Lactobacillus gasseri (UALg-05) - 1.0B CFU*
- » *Lactobacillus rhamnosus (UALr-06) - 1B CFU*
- » *Lactobacillus rhamnosus (UALr-018) - 1B CFU*
- » *Lactobacillus acidophilus (DDS@-1) - 0.5B CFU*
- » *Lactobacillus plantarum (UALp-05) - 0.5B CFU*
- » *Bifidobacterium longum subsp. Longum (UABI-14) - 0.39 CFU Bifidobacterium bifidum (UABb-10) – 0.3B CFU*
- » *Lactobacillus casei (UALc-03) – 0.3B CFU*
- » *Lactobacillus reuteri (UALre-16)- 0.3B CFU*
- » *Lactobacillus lactis (UALl-08) - 0.2b CFU*
- » *Bifidobacterium longum subsp. Infantis (UABi-13)–0.01B CFU*

ХЭРЭГЛЭХ ЗААВАР:


Насанд хүрэгчид: Өсвөр насныхан, 6-аас дээш насны хүүхдүүд: Өдөрт 1 капсулыг хоолны үеэр ууна.

3-5 насны хүүхдүүд (эцэг эхийн хяналтын дор): Өдөрт 1 капсулын доторх нунтаг/агууламжийг шууд хоол, тарагт (гэх мэт) уусах хүртэл холино. Халуун эсвэл халуун хоол, ундаанд нэмж болохгүй. Антибиотик хэрэглэхээс өмнө эсвэл хамгийн багадаа 2-3 цагийн дараа ууна.

АНХААРУУЛГА: Хэрэв та халуунтай, цусан суулгалттай, хэвлийгээр хүчтэй өвдөж байгаа бол хэрэглэхээсээ өмнө эмчээс зөвлөгөө аваарай, хэрэв хоол боловсруулах эрхтний эмгэгийн шинж тэмдэг (жишээлбэл, суулгалт) илэрч, муудах эсвэл 3 хоногос дээш хугацаагаар үргэлжилбэл хэрэглэхээ зогсоож, эмчээс зөвлөгөө аваарай. Дархлаа суларсан тохиолдолд (жишээлбэл, ДОХ, лимфома, кортикостероидын удаан хугацааны эмчилгээ хийлгэж буй өвчтөнүүд) энэ бүтээгдэхүүнийг бүү хэрэглээрэй.

**ГЭДЭС, ХООЛ БОЛОВСРУУЛАХ ЭРХТНИЙ
ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ БҮТЭЭГДЭХҮҮН**

TM/
MC
essentials



ADVANCED PROBIOTIC +B12+ C+D+ZINC 10BILLION №30 КАПСУЛ


Хоол боловсруулах эрхтний эрүүл мэнд, дархлааг дэмжинэ.

НАЙРЛАГА: 1 капсулд:

- » Probiotic complex-10 Billion SFU
- » Bifidobacterium animalis subsp. Lactis (UABla-12) - 3.70 CFU
- » Lactobacillus plantarum (UALp-05) - 3.60 CFU
- » Lactobacillus acidophilus (DDS®-1) - 1.70 CFU
- » Lactobacillus casei (UALc-03) - 0.30 CFU
- » Lactobacillus paracasei (UALpc-04) - 0.30 CFU
- » Lactobacillus lactis (UALl-08) - 0.20 CFU
- » Lactobacillus rhamnosus (UALr-18) - 0.12 CFU
- » Lactobacillus salivarius (UALs-07) - 0.05 CFU
- » Bifidobacterium bifidum (UABb-10) - 0.01 CFU
- » Bifidobacterium longum subsp. Longum (UABl-14) - 0.01 CFU
- » Bifidobacterium breve (UABbr-11) - 0.01 CFU
- » Витамин В12 (Метилкобаламин) - 250 мкг
- » Витамин С (Аскорбины хүчил)-10 мг,
- » Витамин Д3 (Холециальциферол, хаг өвс)-15 мкг/600IU
- » Цайр (цитрат)-11 мг

ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

Насанд хүрэгсэд: Өдөрт 1 капсулыг хоолны үеэр ууна. Антибиотик хэрэглэхээс өмнө эсвэл хамгийн багадаа 2-3 цагийн дараа ууна.



АНХААРУУЛГА:

Хэрэв та халуунтай, цусан суулгалт, хэвлийгээр хүчтэй өвдөж байгаа бол хэрэглэхээсээ өмнө эмчээс зөвлөгөө аваарай, хэрэв хоол боловсруулах эрхтний эмгэгийн шинж тэмдэг (жишээлбэл, суулгалт) илэрч, муудах эсвэл 3 хоногоос дээш хугацаагаар үргэлжилбэл хэрэглэхээ зогсоож, эмчээс зөвлөгөө аваарай. Дархлаа суларсан тохиолдолд (жишээлбэл, ДОХ, лимфома, кортикостероидын удаан хугацааны эмчилгээ хийлгэж буй өвчтөнүүд) энэ бүтээгдэхүүнийг бүү хэрэглээрэй.

ХООЛ БОЛОВСРУУЛАХ ЭРХТНИЙ ЭРҮҮЛ МЭНД, ДАРХЛАА ДЭМЖИХ БҮТЭЭГДЭХҮҮН

DIGESTIVE BOOSTER

143 Г НУНТАГ

Насанд хүрсэн хүмүүсийн хоол боловсруулах фермент болон пребиотикийн нэмэлт эх үүсвэрийн хувьд, тэдгээрийн дутлаас урьдчилан сэргийлэх, дутлыг нөхөх зорилгоор хэрэглэнэ. Хоол боловсруулах замын хэвийн үйл ажиллагааг дэмжиж, хоол боловсруулалтыг сайжруулна.

НАЙРЛАГА: Нэг хэмжээст (5.1 г) халбаганд:

- » Протеаз - 20,000 HUT/25 мг,
- » Лактаз - 100 ALU/50 мг;
- » Цэвэр хуайс- 5 г

ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

Насанд хүрэгчид: Өдөр бүр 1 халбага (5.1 гр) уургийн коктейль, смүүти зэрэг дурын хүйтэн ундаандаа холино. Сайн үр дүнд хүрэхийн тулд хоолны үеэр ууна. Удаан хугацаагаар хэрэглэх бол эмчээс зөвлөгөө аваарай.

АНХААРУУЛГА:

Хэрэв та жирэмсэн эсвэл хөхүүл бол; чихрийн шижин, ходоод гэдэсний гэмтэл, шархлаатай эсвэл мэс засал хийлгэх гэж байгаа; цус шингэлэгч эсвэл үрэвслийн эсрэг эм ууж байгаа бол хэрэглэхийн өмнө эмчээс зөвлөгөө аваарай. Ходоод гэдэсний замын эмгэг, хэт мэдрэгшил/харшил илэрвэл хэрэглэхээ зогсооно уу.



**ХООЛ БОЛОВСРУУЛАХ ЗАМЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ БҮТЭЭГДЭХҮҮН**

PROBIOTIC KIDS CHEWABLE

№60 ЗАЖИЛДАГ ШАХМАЛ

Хүүхдийн ходоод гэдэсний хэвийн бактерийн өсөлтийг ханган, хоол боловсруулах эрхтний эрүүл мэндийг дэмжинэ. Хиймэл амт үнэр орлуулагч агуулаагүй байгалийн гаралтай интоорын амттай зажилдаг шахмал.

НАЙРЛАГА: 1 зажилдаг шахмалд:

- » Probiotic complex- 5 billion complex
- » Bifidobacterium animalis subsp. Lactis (UABla-12)-3.0B CFU
- » Lactobacillus paracasei (UALpc-04)-1.0B CFU
- » Lactobacillus acidophilus (DDS®-1)-0.5B CFU
- » Lactobacillus rhamnosus (UALr-06)-0.4B CFU
- » Lactobacillus salivarius (UALs-07)-0.1B CFU

ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

3 ба түүнээс дээш насны хүүхдэд (эцэг эхийн хяналтын дор): Өдөр бүр 1 шахмалыг зажилна. Антибиотик хэрэглэхээс өмнө эсвэл хамгийн багадаа 2-3 цагийн дараа ууна.



АНХААРУУЛГА:

Хэрэв та халуунтай, цусан суулгалт, хэвлийгээр хүчтэй өвдөж байгаа бол хэрэглэхээсээ өмнө эмчээс зөвлөгөө аваарай, хэрэв хоол боловсруулах эрхтний эмгэгийн шинж тэмдэг (жишээлбэл, суулгалт) илэрч, муудах эсвэл 3 хоногоос дээш хугацаагаар үргэлжилбэл хэрэглэхээ зогсоож, эмчээс зөвлөгөө аваарай. Дархлаа суларсан тохиолдолд (жишээлбэл, ДОХ, лимфома, кортикостероидын удаан хугацааны эмчилгээ хийлгэж буй өвчтөнүүд) энэ бүтээгдэхүүнийг бүү хэрэглээрэй.

ХҮҮХДИЙН ХООЛ БОЛОВСРУУЛАХ ЭРХТНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ БҮТЭЭГДЭХҮҮН

BABY PROBIOTIC DROPS

126 ШИНГЭН ДУСАЛ

Нярай хүүхдийн гэдсэнд байх ёстой гол ашигтай бактери. Хүүхдийн хоол боловсруулах эрхтний эрүүл мэндийг дэмжинэ. Нярай хүүхдийн гэдэсний нянгийн шалтгаант хямралын бүх тохиолдол болон эхийн сүүгээр хооллодоггүй, кесар хагалгаагаар төрсөн, гэдэсний халдварт өвчин, харшлын үед хэрэглэхэд тохиромжтой.

НАЙРЛАГА: Шингэн дусал (6 дусал):

» *Bifidobacterium animalis subsp. Lactis*– 1 тэрбум CFU

ХҮҮХДЭД АШИГТАЙ БАКТЕРИ ӨГСНӨӨР:

Хүүхдийн ходоод гэдэсний замын бичил орчин хэвийн болгох, үйл ажиллагааг сайжруулах, дархлаа тогтолцооны хэвийн үйл ажиллагааг зүгшрүүлэх.

ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

15 секундн турш сайн сэгсэрнэ. Антибиотик хэрэглэхээс 2-3 цагийн өмнө эсвэл дараа ууна.

Нярай болон 1 сар - 3 настай хүүхдэд: Өдөрт нэг удаа 6 дуслыг сүүнд /эхийн сүү/ хийж эсвэл шууд угжинд, халбага эсвэл хүүхдийн хэлэнд дусааж уулгана.

АНХААРУУЛГА:

Найрлагын жагсаалт дах аль нэг нэгдэлд харшилтай хүүхдэд хэрэглүүлж болохгүй. Хэрэв ямар нэгэн эмийн бэлдмэл хэрэглэж байгаа, эсвэл эмчийн хяналтад байдаг (Хүүхэд халуунтай, цусан суулгалт, хэвлийгээр хүчтэй өвдөж байгаа бол), мөн нэмэлтээр дээрх ашигтай бактери хэрэглэх тохиолдолд хэрэглэхийн өмнө өөрийн эмчээсээ зөвлөгөө авна уу. Ямар нэг гаж нөлөө илэрвэл уухыг зогсоож эмчид хандана уу.



НЯРАЙН ХООЛ БОЛОВСРУУЛАХ ЭРХТНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ БҮТЭЭГДЭХҮҮН

essentiolsTM/_{MC}

VITAMIN D3

1000 IU

№200+40 ШАХМАЛ

Витамин Д3 нь эрүүл байдлыг хадгалахад чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд яс, шүдний хэвийн байдлыг хадгалж бие махбодод кальцийг шимэгдэхэд тусалдаг. Д амин дэмийн дутагдлаас сэргийлнэ. Дархлааны үйл ажиллагааг хэвийн хадгалж, эсийн хэвийн хуваагдлын үйл явцад оролцдог. Витамин Д-ийн дутагдал дархлаа сульдал, чихрийн шижин хэв шинж 1, булчин, үе мөчний өвчин мөн түүнчлэн хавдаар өвдөх эрсдлийг нэмэгдүүлдэг гэж судлаачид үзэж байна.

НАЙРЛАГА:

Холекальциферол..... 1 шахмал бүрд 1000 ОУН /25 мкг

Д ВИТАМИН НЬ ДАРААХ ҮҮРЭГТЭЙ:

Дархлаа тогтолцоо. Витамин Д3 нь зохистой түвшинд байснаар биеийн дархлаа тогтолцооны хэвийн үйл ажиллагааг хангана.

Ясны эрүүл мэнд. Витамин Д, Д3-ийн идэвхтэй хэлбэрүүд нь ясны бат бөх байдлыг үүсгэх кальци болон фосфорын шингээлтийг нэмэгдүүлж өгдөг.

Амьсгалын эрхтэн тогтолцоо. Витамин Д3 нь дархлааны тогтолцоо болон амьсгалын замын эрхтэн тогтолцооны эрүүл байдлыг дэмждэг.

Зүрх судасны тогтолцоо. Хүүхэд болон насанд хүрсэн хүмүүсийн зүрх судасны эрхтэн тогтолцооны эрүүл байдлыг хангаж өгдөг.

ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

Насанд хүрэгчид: Өдөрт 1 шахмалаар ууна.



ВИТАМИН Д3-ЫН ДУТАГДЛААС СЭРГИЙЛЭХ БҮТЭЭГДЭХҮҮН

TM/ MC
essentiols

BABY D3 DROPS

400 IU №1
ШИНГЭН ДУСАЛ

Хүүхдийн эрүүл хөгжил, дархлаа тогтолцооны хэвийн үйл ажиллагааг дэмжинэ. Яс, шүдний эрүүл хөгжилд тустай.

НАЙРЛАГА:

Витамин D3 0.18612 г

Д ВИТАМИН НЬ:

- » Кальцийн эргэн шимэгдэлтийг сайжруулснаар яс болон шүдийг бэхжүүлэх
- » Дархлаа сайжруулах

Витаминууд дундаас хамгийн чухал нь Д витамин байдаг.

ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

Жижиг лонхны бөглөөг нь аваад, лонхыг бүхэлд нь доош нь харуулан эргүүл. Бэлдмэл өөрөө дусах тул савыг сэгсэрч болохгүй. Дуслыг хөхний сүүнд нэмж эсвэл хүүхдийн хэлэн дээр шууд дусааж хэрэглэнэ. Baby-D3™ дуслыг хэрэглэхэд хялбар. Нярай болон бага (0-12) насны хүүхдүүдэд хоногт 1-2 дуслаар уулгана.



ВИТАМИН ДЗ-ЫН ДУТАГДЛЫГ НӨХӨХ, ХАЛДВАРААС СЭРГИЙЛЖ, ДАРХЛАА ДЭМЖИХ БҮТЭЭГДЭХҮҮН

TM/ MC
essentiols

WILD SALMON AND FISH OIL OMEGA-3 COMPLEX

№180+20Ш ЗӨӨЛӨН ГЕЛЬ

Зүрх, тархины эрүүл мэндийг дэмжинэ.

Зүрхний эрүүл мэнд, тархины эрүүл мэндийг дэмжих ач тустай ба удаан хугацаагаар хэрэглэвэл эерэг сэтгэл зүй, үе мөчний хүч чадал, дархлааг хамгаалах болно. Хүний тархины 60 хүртэлх хувийг өөх тос бүрдүүлдэг. Үүний 50 гаруй хувийг зөвхөн DHA /Docosa Hexaenoic Acid/ омега-3 тосны хүчил дангаараа үүсгэдэг ба DHA нь хүний тархи дахь хамгийн чухал тэжээл юм. Загасны тосноос гаргаж авсан омега-3 нь тархины хөгжил, үйл ажиллагааг дэмжиж өгдөг гол тэжээл болох DHA /Docosa Hexaenoic Acid/-ны өндөр агууламжтай. Омега-3 тай нэмэлт тэжээлүүд нь дутуу төрөх эрсдэлийг бууруулах, хүүхдийн IQ-г сайжруулах, нүдний хөгжлийг дэмждэг болохыг олон судалгаануудад харуулсан байдаг.

НАЙРЛАГА: Нэг зөөлөн гельд:

- » Молекулын нэрмэл зэрлэг хулд ба загасны тос (Аляскийн зэрлэг хулд, Менхаден)- 1000 мг буюу Омега-3 тосны хүчил-200 мг үүнд:
- » Эйкозапентаены хүчил (EPA)-100 мг
- » Докозагексаены хүчил (DHA)-100 мг

ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

Насанд хүрэгсэд: Өдөрт 1 зөөлөн гель ууна.



ЗҮРХ, ТАРХИНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ БҮТЭЭГДЭХҮҮН

OMEGA-3

700 МГ №100

ЗӨӨЛӨН КАПСУЛ

Омега-3 700 мг зөөлөн капсул нь холестериньг бууруулж зүрх судасны үйл ажиллагааг дэмжинэ. Уусны дараа загас амтагдахгүй.

НАЙРЛАГА:

Эйкозапентены хүчил (EPA) 420 мг

Докозагексаны хүчил (DHA) 280 мг

Анчоус, Сардин, Макрел зэрэг загаснуудын 1,165 мг нэрмэл тос бөгөөд энэ нь 700 мг Омега-3 тосны хүчлийг агуулна.

ХЭРЭГЛЭХ ЗААЛТ:

- » Цусан дахь холестриныг бууруулах
- » Судас цэвэрлэх
- » Артерийн даралтыг тогтворжуулах
- » Элэгний өөхжилтийг бууруулах
- » Ой санамжийг сайжруулах
- » Сэтгэл гутрал
- » Стресс
- » Хөгшрөлтийг удаашруулах

ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

Насанд хүрэгчид: Хоногт 1-4 зөөлөн капсулыг ууж хэрэглэнэ.



**ХОЛЕСТЕРИН БУУРУУЛЖ, ЗҮРХ СУДАСНЫ ЭРҮҮЛ
МЭНДИЙГ ДЭМЖИХ БҮТЭЭГДЭХҮҮН**

TM/MC
essenti  **is**

PRENATAL DHA

№60 ЗӨӨЛӨН ГЕЛЬ

Prenatal DHA нь ургийн тархины эрүүл хөгжлийг дэмжинэ. Хэвийн жирэмслэлтийг хангахад шаардлагатай тохиромжтой тун бүхий бичил элементийг агуулсан. Фолийн хүчил нь ургийн мэдрэлийн сувгийн буруу хөгжлөөс сэргийлнэ. Жирэмсэн ба хөхүүл үеийн амин дэм ба эрсдэлийн дутагдлаас урьдчилан сэргийлнэ. Жирэмсэн үеийн төмөр дутлын цус багадалтад ба кальцийн хэрэгцээг нөхнө.

НАЙРЛАГА:

- » **Амин дэм:** Витамин А -1050мкг, Бета-Каротин-1500мкг, Витамин В1 - 1.4мг, Витамин В2 - 1.6мг, Витамин В3-18мг, Витамин В5 -7 мг, витамин В6 -5 мг, витамин В12-2.8мкг, витамин С-120мг, витамин Д3-15 мкг/600 ОУН, витамин Е – 19мг АТ/28 ОНУ, витамин К1-90 мкг, Биотин-35мкг, фолийн хүчил-1000мкг
- » **Эрдэс бодис:** Кальци-100мг, хром -25мкг, зэс -267 мкг, иод -150 мкг, төмөр – 27мг, Магни - 25 мг, манган- 2 мг, молибден - 50 мг, селен - 60 мкг, цайр - 20 мг

ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

Насанд хүрсэн эмэгтэйчүүд: Жирэмслэхээр төлөвлөж буй, жирэмсэн болон хөхүүл үед өдөрт 1 зөөлөн гель хоолны хамт ууна. Бусад эм эсвэл байгалийн гаралтай эрүүл мэндийн бүтээгдэхүүнийг хэрэглэхээс хэдэн цагийн өмнө эсвэл дараа ууна.



АНХААРУУЛГА:

Хүүхдийн гар хүрэхгүй газар хадгална. Уг савлалтад хүүхдэд ноцтой хор хөнөөл учруулах хангалттай хэмжээний эм (төмөр) агуулна. Хэрэв та цус шингэлэх эм хэрэглэж байгаа бол хэрэглэхээсээ өмнө эмчээс зөвлөгөө аваарай. Хэт мэдрэмтгий байдал үүсвэл хэрэглэхээ зогсоо.

**ЖИРЭМСЭН БОЛОН ХӨХҮҮЛ ҮЕИЙН АМИН ДЭМ,
ЭРДСИЙН ДУТАГДАЛААС СЭРГИЙЛЭХ БҮТЭЭГДЭХҮҮН**

PRENATAL CHEWABLE MULTI

№60 ЗАЖИЛДАГ
ШАХМАЛ

Jamieson 100% Complete Prenatal Multivitamin нь жирэмсэн эхчүүдэд санал болгож буй витаминуудын 100% ба түүнээс дээш хувийг өдөрт нэг шахмалаар хангадаг Канад улсын анхны зажилдаг олон төрлийн амин дэм юм. Жирэмсэн болон хөхүүл эхчүүдийн аминдэм болон эрдэс бодисын дутлаас урьдчилан сэргийлэх, дутлыг нөхөх биологийн идэвхт бүтээгдэхүүн.

НАЙРЛАГА:


- » **Амин дэм:** Витамин А -1050мкг, Бета-Каротин-1500мкг, Витамин В1 - 1.4мг, Витамин В2 - 1.6мг, Витамин В3-18мг, Витамин В5 -7 мг, витамин В6 -5 мг, витамин В12-2.8мкг, витамин С-120мг, витамин Д3-15 мкг/600 ОУН, витамин Е – 19мг АТ/28 ОНУ, витамин К1-90 мкг, Биотин-35мкг, фолийн хүчил-1000мкг
- » **Эрдэс бодис:** Кальци-150мг, хром -30мкг, зэс -1000 мкг, иод -220 мкг, төмөр – 16мг, Магни - 50 мг, манган- 2 мг, молибден - 50 мг, селен - 60 мкг, цайр – 7.5 мг

ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

Насанд хүрсэн эмэгтэйчүүд: Жирэмслэхээс өмнө, жирэмсэн болон хөхүүл үед өдөрт 1 шахмалыг хоолны хамт ууна. Бусад эм эсвэл байгалийн гаралтай эрүүл мэндийн бүтээгдэхүүнийг хэрэглэхээс хэдэн цагийн өмнө эсвэл дараа ууна.

АНХААРУУЛГА:

Хүүхдийн гар хүрэхгүй газар хадгална. Уг савлалтанд хүүхдэд ноцтой хор хөнөөл учруулах хангалттай хэмжээний эм (төмөр) агуулна. Хэрэв та цус шингэлэх эм хэрэглэж байгаа бол хэрэглэхээсээ өмнө эмчээс зөвлөгөө аваарай. Хэт мэдрэмтгий байдал үүсвэл хэрэглэхээ зогсоо.



**ТӨМӨР, ИОД, ФОЛИЙН ХҮЧЛЭЭР БАЯЖУУЛСАН
ЖИРЭМСЭН БОЛОН ХӨХҮҮЛ ҮЕИЙН БҮТЭЭГДЭХҮҮН**

MULTI WOMEN 50+

№90 КАПЛЕТ

Эмэгтэйчүүдэд зориулсан мультвитамин нь шаардлагатай бүх амин дэм болон эрдэс бодисыг нэг дор тохиромжтой хэлбэрээр агуулдаг хүнсний нэмэлт бүтээгдэхүүн юм. Өдөр тутмын витаминуудыг хэрэгцээг 100% ба түүнээс дээш хэмжээнд хангана. Олон төрлийн амин дэмийг өдөр бүр хэрэглэх нь шим тэжээлийн дутагдлыг тэнцвэржүүлж, өдрийн турш эрч хүчээр хангаж, яс, хумсыг бэхжүүлж, дархлааг дэмжих, нойрны чанарыг сайжруулж, стрессийн түвшин бууруулахад тусалдаг.

НАЙРЛАГА:

- » **Амин дэм:** Витамин А- 400 мкг, бета-каротин-600 мкг, Витамин В1 - 3.85 мг, Витамин В2 - 3.85 мг, Витамин В3 - 14 мг, Витамин В5 - 11 мг, Витамин В6 - 5 мг, Витамин В12 - 12 мкг, Витамин С - 150 мг, Витамин Д3 - 20 мкг/800 ОНУ, Витамин Е - 26.8 мг, Витамин К1- 90 мкг, Биотин-45 мкг, Фолийн хүчил - 400 мкг;
- » **Эрдэс бодис:** Кальци - 200 мг, хром - 100 мкг, зэс - 900 мкг, иод (калийн иодид) - 150 мкг, төмөр - 6 мг, манган - 3 мг, молибден - 50 мкг, селен - 55 мкг, цайр - 8 мг;
- » **Тэжээллэг бодис:** Цангис - 10 мг, Лютеин - 600 мкг, Ликопен-300 мкг

ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

50+-ээс дээш насны эмэгтэйчүүд: Өдөрт 1 каплетыг хоолны хамт ууна. Бусад эм, байгалийн гаралтай эрүүл мэндийн бүтээгдэхүүнийг хэрэглэхээс өмнө эсвэл хэдэн цагийн дараа ууна.

АНХААРУУЛГА:

Энэ бүтээгдэхүүн нь хүүхдэд ноцтой хор хөнөөл учруулах хангалттай хэмжээний эм (төмөр) агуулдаг. Хүүхэд хүрэхгүй газар хадгална уу. Хэрэв та цус шингэлэх эм ууж байгаа эсвэл бөөрний чулуутай байсан бол хэрэглэхээсээ өмнө эмчээс зөвлөгөө аваарай. Хэт мэдрэг байдал үүсвэл хэрэглэхээ зогсоо.



**ЭМЭГТЭЙЧҮҮДЭД ЗОРИУЛСАН АМИН ДЭМ, ЭРДЭС БОДИС,
АНТИОКСИДАНТ АГУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН**

WOMEN'S MULTI GUMMIES №130 ГАММИС

Эмэгтэйчүүдэд зориулсан Jamieson Multivitamin Gummies нь эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг бүхэлд нь дэмжих зорилгоор бүтээгдсэн. Арьсыг эрүүлжүүлж, бодисын солилцоо, дархлааны үйл ажиллагааг дэмжинэ.

НАЙРЛАГА: Нэг гаммист:

- » **Амин дэм:** Витамин А – 604,3 мкг/2000 IU, Витамин В5 – 5 мг, Витамин В6 – 2,5 мг, Витамин В12 – 7,5 мг, Витамин С – 37,5 мг, Витамин Д3 – 5 мкг/200 IU, Витамин Е – 6,9 мг, Биотин – 250 мкг, Холин – 30 мкг, Фолийн хүчил – 200 мкг, Инозит – 20 мкг
- » **Эрдэс бодис:** Иод – 75 мкг, Селен – 55 мкг, Цайр – 2.5 мг,

ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

Насанд хүрсэн эмэгтэйчүүд: Өдөр бүр хоолны үеэр 2 ширхэг гаммис зажилж ууна. Бусад эм, байгалийн гаралтай эрүүл мэндийн бүтээгдэхүүнийг хэрэглэхийн өмнө эсвэл хэдэн цагийн дараа ууна.

АНХААРУУЛГА:

Хэрэв та меланома бус арьсны хорт хавдартай бол хэрэглэхээсээ өмнө эмчээс зөвлөгөө аваарай.



**ДАРХЛАА, БОДИСЫН СОЛИЛЦООНЫ ХЭВИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГАА ХАНГАХ, ЭРҮҮЛ АРЬСЫГ ДЭМЖИХ БҮТЭЭГДЭХҮҮН**

MULTI 100% COMPLETE MEN 50+ №90 БҮРМЭЛ

50+ насны эрэгтэйчүүдийн эрүүл мэндэд тустай, амин дэмийн хэрэгцээг хангаж, энергийн түвшин, эрч хүчийг нэмэгдүүлэн, тархины үйл ажиллагаа, дархлааг дэмжих энэхүү бүтээгдэхүүн нь шинжлэх ухаанаар батлагдсан бөгөөд эрэгтэйчүүдийн эрүүл, идэвхтэй амьдралыг дэмжинэ.

НАЙРЛАГА:

- » **Амин дэм:** Витамин А-300мкг, Бета-каротин-1800мкг, Витамин В1 - 4.2 мг, Витамин В2 -4.6 мг, Витамин В3 - 16 мг, Витамин В5-12.5 мг, Витамин В6 - 8.5 мг, Витамин В12 - 12 мкг, Витамин С - 180 мг, Витамин D3 -20 мкг/800 IU, Е витамин- 22.5 мг АТ/33.6 IU, Витамин К1-120 мкг, Биотин-54 мкг, Фолат (фолийн хүчил)-400 мкг
- » **Эрдэс бодис:** Кальци -200 мг, хром (хлорид) - 150 мкг, зэс (сульфат) - 500 мкг, иод (калийн иодид) - 150 мкг, төмөр (төмрийн фумарат) - 2 мг, Магни (оксид) - 125 мг, манган (сульфат) 3 мг, Молибден (натрийн молибдат) - 50 мкг, селен (натрийн селенит) - 65 мкг, цайр (оксид) - 11 мг,
- » **Тэжээллэг бодис:** Сибирийн хүн орхоодойн (45:1) ханд - 6 мг, Лютеин -600 мкг, Ликопен - 300 мкг

ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

50 дээш насны эрэгтэйчүүд: Өдөрт 1 бүрмэлийг хоолны хамт ууна.



АНХААРУУЛГА:

Найрлагын жагсаалт дахь аль нэг нэгдэлд харшилтай бол хэрэглэж болохгүй. Хэрэв ямар нэгэн эмийн бэлдмэл хэрэглэж байгаа, эсвэл эмчийн хяналтанд байдаг, мөн нэмэлтээр дээрхи аминдэм болон эрдэс бодис хэрэглэх тохиолдолд хэрэглэхийн өмнө өөрийн эмчээсээ зөвлөгөө авна уу. Зөвлөсөн тун, хэмжээнээс хэтрүүлж хэрэглэхийг хориглоно. Бүтээгдэхүүний хадгалалтын хугацаа дууссан бол хэрэглэхгүй. Хүүхдийн гар хүрэхгүй газар хадгална уу. Биологийн идэвхт бүтээгдэхүүн нь нэмэлтээр хэрэглэх бүтээгдэхүүн болохоос олон төрлийн, тэнцвэртэй хооллолт, эрүүл амьдралын хэв маягийг орлохгүй. Ямар нэг гаж нөлөө илэрвэл уухыг зогсоож эмчид хандана уу.

**БАЙГАЛИЙН ЭРЧ ХҮЧ, ДАРХЛАА
ДЭМЖИХ БҮТЭЭГДЭХҮҮН**

MULTI 100% COMPLETE MEN №90 БҮРМЭЛ

Насанд хүрсэн хүмүүсийн дээрхи аминдэм болон эрдэс бодисуудын нэмэлт эх үүсвэрийн хувьд, тэдгээрийн дутлаас урьдчилан сэргийлэх, дутлыг нөхөх зорилгоор, биологийн идэвхит бүтээгдэхүүний зориулалтаар хэрэглэнэ. Энэхүү иж бүрдэл дархлааны тогтолцооны хэвийн үйл ажиллагааг дэмжиж, дархлааны тогтолцооны эрүүл хариу урвалыг идэвхжүүлэхэд тустай.

НАЙРЛАГА:

- » **Амин дэм:** Витамин А-400мкг, Бета-каротин-1000мкг, Витамин В1 - 4.2 мг, Витамин В2 -4.6 мг, Витамин В3 - 16 мг, Витамин В5-12.5 мг, Витамин В6 - 5.5 мг, Витамин В12 - 12 мкг, Витамин С - 180 мг, Витамин D3 -20 мкг/800 IU, Е витамин- 26.8 мг АТ/40 IU, Витамин К1-120 мкг, Биотин-54 мкг, Фолат (фолийн хүчил)-400 мкг,
- » **Эрдэс бодис:** Кальци -200 мг, хром (хлорид) - 35 мкг, зэс (сульфат) - 900 мкг, иод (калийн иодид) - 150 мкг, төмөр (төмрийн фумарат) - 6 мг, Магни (оксид) - 84 мг, манган (сульфат) 5.5 мг, селен (натри селенит) - 55 мкг, цайр (оксид) - 11 мг,
- » **Тэжээллэг бодис:** Сибирийн хүн орхоодойн (45:1) ханд - 6 мг, Лютеин -1000 мкг, Ликопен -600 мкг

ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

Насанд хүрсэн эрэгтэйчүүд: Өдөрт 1 бүрмэлийг хоолны хамт ууна.

АНХААРУУЛГА:

Зөвхөн насанд хүрсэн хүмүүст зориулсан. Найрлагын жагсаалт дахь аль нэг нэгдэлд харшилтай бол хэрэглэж болохгүй. Хэрэв ямар нэгэн эмийн бэлдмэл хэрэглэж байгаа, эсвэл эмчийн хяналтанд байдаг, мөн нэмэлтээр дээрх аминдэм болон эрдэс бодис хэрэглэх тохиолдолд хэрэглэхийн өмнө өөрийн эмчээсээ зөвлөгөө авна уу. Зөвлөсөн тун, хэмжээнээс хэтрүүлж хэрэглэхийг хориглоно. Биологийн идэвхит бүтээгдэхүүн нь нэмэлтээр хэрэглэх бүтээгдэхүүн болохоос олон төрлийн, тэнцвэртэй хооллолт, эрүүл амьдралын хэв маягийг орлохгүй. Ямар нэг гаж нөлөө илэрвэл уухыг зогсоож эмчид хандана уу.



**БАЙГАЛИЙН ЭРЧ ХҮЧ, ДАРХЛАА
ДЭМЖИХ БҮТЭЭГДЭХҮҮН**

SAW PALMETTO

1000 МГ №30+30
ЗӨӨЛӨН ГЕЛЬ

Түрүү булчирхайн эрүүл үйл ажиллагааг дэмжинэ.

Насанд хүрэгсдийн хөнгөн болон дунд зэргийн түрүү булчирхайн шинж тэмдгүүд тухайлбал шээсний урсац гарахгүй байх, өдөр, шөнийн цагаар байнга шээх зэрэг шинж тэмдгийн арилгахад тустай.

НАЙРЛАГА:

» Со Пальметто ханд (8:1) -125 mg

ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

Насанд хүрсэн эрэгтэйчүүд: Ходоодны хямрал үүсгэхгүйн тулд өдөрт 1 зөөлөн гелийг хоолны үеэр ууна.



АНХААРУУЛГА:

Хэрэв шинж тэмдгүүд арилахгүй, муудаж байвал эсвэл хэрэглэхийн өмнө түрүү булчирхайн хорт хавдрын оношийг харгалзан эмчээс зөвлөгөө аваарай.

ТҮРҮҮ БУЛЧИРХАЙН ХЭВИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ БҮТЭЭГДЭХҮҮН

POWER FOR MEN

№60 БҮРМЭЛ

Энэхүү бэлдмэл нь тестостероны хэвийн үйл ажиллагааг дэмжиж, булчингийн хүчийг нэмэгдүүлнэ.

Насанд хүрсэн бүх насны эрчүүд биологийн идэвхит бүтээгдэхүүний зориулалтаар хэрэглэнэ. Фитнесээр хичээллэж буй залуус булчингийн хүчийг нэмэгдүүлэх, ахимаг насны эрэгтэйчүүд тестостерон даавраа нэмэгдүүлэх зорилгоор хэрэглэхэд илүү үр дүнтэй.

НАЙРЛАГА:

- » Бета-аланин-50 мг
- » Бор (цитрат)- 230 мкг
- » Фенугрек (Trigonella foenum-graecum, үр)-33.3 мг
- » Магни (аспарат) 150 мг
- » Витамин В6 (пиридоксин HCl)-3.5 мг
- » Цайр (монометионин, аспарат)- 10 мг

ХЭРЭГЛЭХ ЗААЛТ:

- » Тестостерон дааврын үйл ажиллагааг дэмжих
- » Булчингийн хүчийг нэмэгдүүлэхэд туслах
- » Бие дэх энергийн солилцоог дэмжих

ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

Насанд хүрсэн эрэгтэй: Өдөрт 3 шахмалыг хоолны хамт ууна. Бусад эмийг хэрэглэснээс хэдэн цагийн өмнө эсвэл дараа нь ууна.

АНХААРУУЛГА:

Зөвхөн насанд хүрсэн хүмүүсд зориулсан. Найрлагын жагсаалт дах аль нэг нэгдэлд харшилтай бол хэрэглэж болохгүй. Зөвлөсөн тун, хэмжээнээс хэтрүүлж хэрэглэхийг хориглоно. Хүүхдийн гар хүрэхгүй газар хадгална уу. Ямар нэг гаж нөлөө илэрвэл уухыг зогсоож эмчид хандана уу.



**ТЕСТОСТЕРОН ДААВРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИЖ,
БУЛЧИНГИЙН ХҮЧИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ БҮТЭЭГДЭХҮҮН**

MAGNESIUM GUMMIES

№60

Яс болон шүдний бат бөх байдлыг дэмжиж, булчингийн зохистой үйл ажиллагааг хадгалахад тусална.

Бие махбодын 600 гаруй ферментийн зохицуулгад оролцдог. Цусны даралтын бууруулдаг. Булчингийн үйл ажиллагааны зохицуулгад оролцдог. Мэдрэлийн системийг тайвшруулж, толгой өвдөх, сэтгэлийн хямралыг намдааж, стрессийн даавар кортизолыг зохицуулахад тусалдаг. Дасгал хийх явцад таны бие амарч байх үеийнхээс 10-20% илүү магни авах шаардлагатайг болдог. Учир нь бид хөлрөхдөө натри, хлорид, кали болон магни гэх мэт эрдэс бодисоо алддаг. Тиймээс магнийн нэмэлт тэжээл нь тамирчид, өндөр настан, архаг өвчтэй хүмүүсийн хөдөлгөөний чадварыг сайжруулдаг гэж судлаачид үздэг.

МАГНИ АЧ ХОЛБОГДОЛ

- » Сэтгэл санаа мэдрэлийн үйл ажиллагааг сайжруулж тайвшруулах
- » Булчингийн чангарлыг сулруулж, шөрмөс таталтыг багасгах
- » Нойрны чанарыг сайжруулж, нойргүйдлийг багасгах
- » Толгойн өвдөлтийн давтамжийг бууруулах
- » Дархлаа тогтолцооны үйл ажиллагааг зохицуулах

НАЙРЛАГА: Нэг гаммист:

- » Магни(бисглицинат) - 20 мг



ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

Насанд хүрэгчид: Өдөрт 1-2 гаммисыг зажилж ууна.

АНХААРУУЛГА:

Энэхүү бүтээгдэхүүн нь эм биш бөгөөд нэмэлтээр хэрэглэх биологийн идэвхит бүтээгдэхүүн ба хоол тэжээлийг орлохгүй.

**ЯС БОЛОН ШҮДНИЙ БАТ БӨХ БАЙДЛЫГ ДЭМЖИЖ, БУЛЧИНГИЙН
ЗОХИСТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХ БҮТЭЭГДЭХҮҮН**

ZINC

10 МГ №100 ШАХМАЛ

Цайр нь 300 гаруй ферментийн бүрэлдэхүүн хэсэг болдог ба олон тооны бодисын солилцооны үйл явцад оролцдог. Дархлааны хариу урвалд оролцдог Т, В эсийн ерөнхий өсөлтийг дэмждэг. Цайрын ашиг тус нь антиоксидант шинж чанартай байдаг бөгөөд судалгаагаар энэ нь үрэвслээс урьдчилан сэргийлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

ЦАЙРЫН ДАВУУ ТАЛ:

- » Жирэмслэлт болон нөхөн үржихүйн хэвийн үйл ажиллагааг хангах;
- » Цусан дахь тестостероны түвшин хэвийн хэмжээнд байлгах;
- » Эсийн хуваагдах үйл явцад чухал үүрэг гүйцэтгэх, эсийг исэлдэх үйл явцаас хамгаалах;
- » Яс, арьс, үс, хумсны хэвийн үйл ажиллагааг хангах;
- » Танин мэдэхүй, нүдний харааны хэвийн үйл ажиллагаанд оролцох;
- » Бие махбодын нүүрс ус, өөх тос, уургийн солилцоог дэмждэг.

НАЙРЛАГА:

Цайр (глюконатын давс)10 мг

ХЭРЭГЛЭХ ЗААЛТ:

- » Дархлаа тогтолцооны хэвийн байдлыг хангах
- » Нөхөн үржихүйн хэвийн үйл ажиллагааг дэмжих
- » Дааврын тэнцвэрийг хангах
- » Булчингийн өсөлтийг дэмжих
- » Суулгалтыг зогсоох гэх мэт

ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

Насанд хүрэгчид: Өдөрт 1 шахмалыг хооллох үедээ ууна.

АНХААРУУЛГА:

Бүтээгдэхүүнийг нь жирэмсэн болон хөхүүл эхчүүд, 6-аас доош насны хүүхдүүд хэрэглэхгүй. Цайрын илүүдэл нь ээсийн дутагдалд хүргэдгийг анхаарах шаардлагатай. Хэрэв та өөр эм хэрэглэж байгаа бол эм хоорондын зайг 1-2 цагийн зайтай уухыг анхаарна уу.



**ДАРХЛАА ДЭМЖИЖ, НӨХӨН ҮРЖИХҮЙН ХЭВИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААГ ХАНГАХ БҮТЭЭГДЭХҮҮН**

GENTLE IRON

28 МГ №90
КАПСУЛ

Төмрийн далд дутагдлын эмчилгээ болон жирэмсэн үеийн төмрийн дутагдлаас урьдчилан сэргийлнэ. Хүний биед агуулагдах төмрийн хэмжээ хэвийн хэмжээнээс багассанаас болж улаан эс хүчилтөрөгч зөөх уургыг (гемоглобин) ялгаруулж чадахгүйд хүрдэг. Үүний үр дүнд ядрах, сульдах, арьс цонхийх, цээжээр өвдөх, зүрх дэлсэх, амьсгал давчдах, толгой өвдөх, толгой эргэх эсвэл ухаан балартах, гар хөл хүйтэн болох, хэл хавагнах, хумс хэврэгших, хоолны дуршил буурах гэх мэт шинж тэмдгүүд илэрнэ.

НАЙРЛАГА:

- » Төмөр-28 мг (Төмрийн бисглицинат)
- » Витамин В2-800 мкг,
- » Витамин В12-8 мкг,
- » Витамин С-60 мг,
- » Фолийн хүчил-400 мкг

ХЭРЭГЛЭХ ЗААЛТ:

- » Бие махбодын болон оюун санааны ачаалал ихсэх
- » Төмрийн дутагдлын үед
- » Байгалийн төмрийн агууламж багатай хоолны дэглэмийн үед
- » Хоолны дуршил алдагдах
- » Төмрийн хэрэгцээ ихсэх, тухайлбал, сарын тэмдэг их ирэх, жирэмслэлтийг төлөвлөх, жирэмслэлт, хөхүүл үед, өсвөр насны хүүхдүүд, өндөр настнуудад.



ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

Насанд хүрэгчид: Өдөрт 1 капсулыг хоолны үеэр ууна. Байгалийн гаралтай болон бусад эм хэрэглэх тохиолдолд өмнө эсвэл хэдэн цагийн дараа ууна.

АНХААРУУЛГА:

Зөвхөн насанд хүрсэн хүмүүст зориулсан. Хүүхдийн гар хүрэхгүй газар хадгална уу. Энэ бүтээгдэхүүн нь хүүхдэд хор хөнөөл учруулах хангалттай хэмжээний эм (төмөр) агуулна. Хэт мэдрэг байдал үүсвэл хэрэглээхэ зогсооно.

**ЦУС БАГАДАЛТЫН УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ БҮТЭЭГДЭХҮҮН**

VITAMIN B COMPLEX №60 КАПЛЕТ

Мэдрэлийн системийн үйл ажиллагааг сайжруулна.

В бүлгийн витаминууд нь эрчим хүч үйлдвэрлэлд тусалдаг, мэдрэлийн системийг дэмжих, стрессийн түвшинг бууруулах, танин мэдэхүйн үйл ажиллагааг сайжруулах мөн зүрхний эрүүл мэндийг хамгаалахад тусалдаг. Таны өдрийн В витаминь хэрэгцээг бүрэн хангаж, энерги, тархины үйл ажиллагаа, эд эсийн бодисын солилцоонд шууд нөлөөлөх бүтээгдэхүүн.

В БҮЛГИЙН ВИТАМИНЫ ОНЦЛОГ ДАВУУ ТАЛ:

- » Дархлааны системийг сайжруулах
- » Мэдрэлийн системийн өвчнүүд
- » Мэдрэлийн ядаргаа
- » Мегалобластын анеми
- » Архаг цус багадалт
- » Судасны хатуурал
- » Арьсны үрэвсэл г.м

НАЙРЛАГА: 1 каплет бүрд

Витамин В1 (Тиамин мононитрат)	100 мг
Витамин В2 (Рибофлавин)	100 мг
Витамин В3 (Ниацинамид)	100 мг
Витамин В5 (Пантетин)	10 мг
Витамин В6 (Пиридоксин)	10 мг
Витамин В12 (Метилкобаламин)	500 мкг
Витамин Н (Биотин)	200 мкг
Витамин В4 (Холин)	10 мг
Фолат (Фолийн хүчил)	1000 мкг
Витамин В8 (Инозитол)	10 мг

ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

Насанд хүрэгчид: Өдөрт 1 каплетийг хооллох үедээ ууна.



**МЭДРЭЛИЙН СИСТЕМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ
САЙЖРУУЛАХ БҮТЭЭГДЭХҮҮН**

STRESSEASE

№90 КАПЛЕТ

Насанд хүрсэн хүмүүсийн аминдэм болон эрдэс бодисуудын нэмэлт эх үүсвэрийн хувьд, тэдгээрийн дутлаас урьдчилан сэргийлэх, дутлыг нөхөх зорилгоор, биологийн идэвхит бүтээгдэхүүний зориулалтаар хэрэглэнэ. Энэхүү иж бүрдэл дархлалын тогтолцооны хэвийн үйл ажиллагааг дэмжиж, стрессээс үүдэлтэй хямралыг бууруулахад тустай.

НАЙРЛАГА:

Амин дэм:

- » Витамин В1-35мг
- » Витамин В2-35мг
- » Витамин В3-50мг
- » Витамин В5-20мг
- » Витамин В6-15мг
- » Витамин В12-30мкг
- » Витамин Е-20мг
- » Витамин С-500мг
- » Биотин 15мкг
- » Фолат-1мг

Эрдэс бодис:

- » Кальци-150мг
- » Магни-75мг
- » Цайр-5мг

ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

Насанд хүрэгчид: Өдөрт 1 бүрмэлийг хоолны хамт ууна.

АНХААРУУЛГА:

Зөвхөн насанд хүрсэн хүмүүст зориулсан. Найрлагын жагсаалт дахь аль нэг нэгдэлд харшилтай бол хэрэглэж болохгүй. Хэрэв ямар нэгэн эмийн бэлдмэл хэрэглэж байгаа, эсвэл эмчийн хяналтад байдаг эсвэл жирэмсэн, жирэмсэн болохоор төлөвлөж байгаа, хөхүүл эх, мөн нэмэлтээр дээрх аминдэм болон эрдэс бодис хэрэглэх тохиолдолд хэрэглэхийн өмнө өөрийн эмчээсээ зөвлөгөө авна уу. Зөвлөсөн тун, хэмжээнээс хэтрүүлж хэрэглэхийг хориглоно. Ямар нэг гаж нөлөө илэрвэл уухыг зогсоож эмчид хандана уу.



**СТРЕССЭЭС ҮҮДЭЛТЭЙ ХЯМРАЛЫГ
БУУРУУЛАХ БҮТЭЭГДЭХҮҮН**

GINKGO BILOBA

4000 МГ

№60+30 КАПЛЕТ

Гинкго билоба нь судасны ханын уян хатан чанарыг дээшлүүлж, судас тэлэх үйлчилгээ үзүүлж, тромбоцитын идэвхжилтийг сааруулж, цус шингэлэх зэрэг үйлчилгээ үзүүлдэг ургамал юм. Тархи захын эрхтэний цус, хүчилтөрөгчийн эргэлтийг сайжруулахад тусална.

НАЙРЛАГА:

- » Гинкго билобаны ханд (50:1) - 80 мг

ХЭРЭГЛЭХ ЗААЛТ:

- » Ой санамж, сэтгэн бодох чадвар болон анхаарал төвлөрөлтийг сайжруулдаг
- » Судасны ханын уян хатан чанарыг дээшлүүлж, судас тэлнэ
- » Бүх бие организмын цусны эргэлт, зүрхний цусан хангамж, тархины цусан хангамж, дотоод шүүрлийн үйл ажиллагаа, зүрх судас ба мэдрэлийн системийг сайжруулна
- » Цусны нөхөн төлжих чадварыг дээшлүүлж, цусны өтгөрлийг багасгаж, хялгасан судаснууд дахь цусны эргэлтийг нэмэгдүүлдэг

ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

Насанд хүрэгчид: Өдөр бүр 1 шахмалыг хэрэглэнэ.

8 сараас дээш хугацаагаар хэрэглэхийн тулд эмчээс зөвлөгөө аваарай.

АНХААРУУЛГА:

Хэрэв та жирэмсэн эсвэл хөхүүл, эсвэл чихрийн шижин, цусны даралт ихсэх, таталт өгөх эм хэрэглэж байгаа бол хэрэглэхээсээ өмнө эмчээс зөвлөгөө аваарай. Хэрэв та цусны бүлэгнэлтэд нөлөөлдөг эрүүл мэндийн бүтээгдэхүүн (жишээ нь, цус шингэлэгч, цусны бүлэгнэлтийн хүчин зүйл орлуулах, ацетилсалицилын хүчил, ибупрофен, загасны тос, витамин E) ууж байгаа бол уг бүтээгдэхүүн нь цус алдах эрсдэлийг нэмэгдүүлж болзошгүй тул бүү хэрэглээрэй



**ТАНИН МЭДЭХҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН
ОЙ ТОГТООЛТЫГ САЙЖРУУЛАХ БҮТЭЭГДЭХҮҮН**

MELATONIN

10 МГ №60 БҮРМЭЛ

Мелатонин бол тархинд ялгардаг байгалийн гаралтай даавар бөгөөд таны нойрсох - сэрэх мөчлөгийг зохицуулахад тусалдаг. Энэ нь тайвшруулах эм шиг шууд унтуулахын оронд ядарч сульдаж байгаа дохиог тархинд илгээн нойронд бэлтгэхэд тусалдаг.

НАЙРЛАГА:

» Мелатонин –10 мг

ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

Насанд хүрэгчид: Өдөр бүр 1 бүрмэлийг унтахын өмнө ууна. Мелатонин ууснаас хойш 5 цагийн турш машин жолоодох, машин механизм ашиглахыг хориглоно.



АНХААРУУЛГА: Зөвхөн насанд хүрсэн хүмүүст зориулсан. Найрлагын жагсаалт дахь аль нэг нэгдэлд харшилтай бол, хэрвээ та ямар нэгэн эм ууж байгаа, эсвэл эмнэлгийн нөхцөлд эмчийн хяналтад байдаг бол энэ бүтээгдэхүүнийг хэрэглэхийн өмнө өөрийн эмчээсээ зөвлөгөө авна уу. 18-с доош настай, эсвэл жирэмсэн, жирэмсэн болохоор төлөвлөж байгаа, эсвэл хөхүүл эх бол энэ бүтээгдэхүүнийг хэрэглэж болохгүй. Согтууруулах ундаа, нойрмог байдлыг нэмэгдүүлдэг бүтээгдэхүүнтэй хамт уухаас зайлсхий. Хэрэв нойргүйдэл 1 сараас дээш хугацаагаар үргэлжилбэл (архаг нойргүйдэл) эмчээс зөвлөгөө аваарай. Машин, мотоцикл эсвэл техник хэрэгсэл ашиглах үед хэрэглэж болохгүй. Өдрийн зохистой тунгаас хэтрүүлж хэрэглэхийг хориглоно.

**НОЙРНЫ ЧАНАРЫГ САЙЖРУУЛЖ,
НОЙРСОЛТЫГ ДЭМЖИХ БҮТЭЭГДЭХҮҮН**

MELATONIN + TART CHERRY

№30 ЗАЖИЛДАГ ШАХМАЛ

Мелатонин нь тайван нойрсох, нойрны хэвийн хэмнэлийг барихад тустайгаас гадна, цагийн зөрүүнээс үүдсэн ядаргааг багасгах, нойрны чанарыг сайжруулж, нойргүйдэлд тустай. Улмаар хүний ажиллах чадварыг дээшлүүлж, тархины хэвийн үйл ажиллагаа болон дархлааг дэмжинэ.

НАЙРЛАГА:

- » Мелатонин –5 мг
- » Интоорын нунтаг - 100 мг

ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

Насанд хүрэгчид: Өдөр бүр 1 шахмалыг унтахын өмнө ууна. Мелатонин ууснаас хойш 5 цагийн турш машин жолоодох, машин механизм ашиглахыг хориглоно.

АНХААРУУЛГА: Зөвхөн насанд хүрсэн хүмүүст зориулсан. Найрлагын жагсаалт дахь аль нэг нэгдэлд харшилтай бол, хэрвээ та ямар нэгэн эм ууж байгаа, эсвэл эмнэлгийн нөхцөлд эмчийн хяналтад байдаг бол энэ бүтээгдэхүүнийг хэрэглэхийн өмнө өөрийн эмчээсээ зөвлөгөө авна уу. 18-с доош настай, эсвэл жирэмсэн, жирэмсэн болохоор төлөвлөж байгаа, эсвэл хөхүүл эх бол энэ бүтээгдэхүүнийг хэрэглэж болохгүй. Согтууруулах ундаа, нойрмог байдлыг нэмэгдүүлдэг бүтээгдэхүүнтэй хамт уухаас зайлсхий. Хэрэв нойргүйдэл 1 сараас дээш хугацаагаар үргэлжилбэл (архаг нойргүйдэл) эмчээс зөвлөгөө аваарай. Машин, мотоцикл эсвэл техник хэрэгсэл ашиглах үед хэрэглэж болохгүй. Өдрийн зохистой тунгаас хэтрүүлж хэрэглэхийг хориглоно.



**НОЙРНЫ ЧАНАРЫГ САЙЖРУУЛЖ,
НОЙРСОЛТЫГ ДЭМЖИХ БҮТЭЭГДЭХҮҮН**

VALERIAN HERBAL COMPLEX №60 БҮРМЭЛ

Зөвхөн насанд хүрэгдсэд зориулсан бэлдмэл. Нойргүйдлийг арилгах мелатонин агуулаагүй уламжлалт ургамлын гаралтай бэлдмэл. Valerian, Catnip, Hops зэрэг ургамлуудыг анагаах ухаанд мэдрэлийн ядаргааг тайлж, тайвшруулах, хэвийн нойрсолтыг дэмжих, сэтгэцийн стрессээс үүдэлтэй тайван бус байдлыг арилгах зорилгоор хэрэглэнэ. Уламжлалт анагаах ухаанд бамбайн өвсний хандыг нойрыг дэмжих зорилгоор хэрэглэдэг.

НАЙРЛАГА:

- » Валериан ханд (4:1) - 50 мг
- » Хопсний ханд-25 мг
- » Пашшион цэцэгний ханд (4:1) -25 мг
- » Катнип өвсний ханд (5:1) - 20 мг

ХЭРЭГЛЭХ ЗААЛТ:

- » Тайвшуурлах, хэвийн нойрсолтыг дэмжих

ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

Насанд хүрэгсэд: Унтахын өмнө 2-3 капсулыг ууна.



АНХААРУУЛГА:

Архи болон эм, байгалийн гаралтай тайвшруулах үйлчилгээтэй эрүүл мэндийн бүтээгдэхүүнтэй хамт хэрэглэхийг хориглоно. Сэтгэл гутралын болон /эсвэл түүнтэй холбоотой өвчтэй бол хэрэглэхээсээ өмнө эмчээс зөвлөгөө авна уу. Жирэмсэн тохиолдолд хэрэглэхгүй. Хэрэв нойргүйдэл 4 долоо хоногос дээш хугацаагаар үргэлжилбэл (архаг нойргүйдэл) эмчээс зөвлөгөөг авна уу. Найрлагад орсон нэгдэлд мэдрэмтгий бол хэрэглэхийг хориглоно.

ГАЖ НӨЛӨӨ: Зарим хүмүүс нойрмоглох шинж тэмдэг илэрч болно. Тээврийн хэрэгсэл жолоодоход анхаарал болгоомжтой байх хэрэгтэй.

**НОЙРСОЛТЫГ ДЭМЖИХ МЕЛАТОНИН АГУУЛААГҮЙ
УЛАМЖЛАЛТ УРГАМЛЫН ГАРАЛТАЙ БҮТЭЭГДЭХҮҮН**

GRANBERRY COMPLEX №60 КАПСУЛ

Өндөр тунтай цангис жимсний капсул нь шээсний замыг цэвэрлэж, давсгийн эрүүл байдлыг хадгалах антиоксидант үйлдэлтэй бэлдмэл. Байгалийн сахар болох Д-Манноз нэмсэнээрээ давуу талтай онцгой найрлагатай бүтээгдэхүүн юм.

ЦАНГИС ЖИМСНИЙ ДАВУУ ТАЛ:

- » Шээсний замын халдвараас урьдчилан сэргийлнэ;
- » Зүрх судасны үйл ажиллагааг дэмжинэ;
- » Ходоодны шарх, ходоодны хавдраас урьдчилан сэргийлдэг;

Цангис жимс олон төрлийн витамин, эрдэс бодис агуулдаг. Нэг аяга цангис жимс идсэнээр:

- » Витамин С-ийн өдрийн хэрэгцээний 25% -ийг хангана;
- » Витамин А-ийн өдрийн хэрэгцээний 9% -ийг хангана;
- » Витамин К-ийн өдрийн хэрэгцээний 6% -ийг хангана;
- » Калийн өдрийн хэрэгцээний 2%-ийг хангана;
- » Төмөр болон кальцийн өдрийн хэрэгцээний 1% -ийг хангана;
- » Витамин Е-ийн өдрийн хэрэгцээний 8% -ийг хангана;
- » Манганы өдрийн хэрэгцээний 16% -ийг хангана;
- » Зэсийн өдрийн хэрэгцээний 7% -ийг хангана;
- » Витамин В комплексын өдрийн хэрэгцээний 8% -ийг хангана;

НАЙРЛАГА: 1 капсул бүрд
Цангисын ханд - 450 мг
Д-манноз - 50 мг

ХЭРЭГЛЭХ ЗААЛТ: Шээсний замын халдварыг эмчлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэнэ.

ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

Насанд хүрэгчид: Өдөрт 1 капсул хэрэглэнэ. Үр дүн, нөлөөг нь мэдрэхийн тулд 1 сараас дээш хугацаанд тогтмол хэрэглэх нь тохиромжтой.

АНХААРУУЛГА:

Бөөрний чулуутай эсвэл цус шингэлэгч /варфарин/ хэрэглэж байгаа тохиолдолд эмчийн заавраар хэрэглэнэ. Капсулын өнгө бага зэрэг ялгаатай байж болно. Байгалийн гаралтай орц найрлагатай тул энэ нь хэвийн үзэгдэл юм.



**ШЭЭСНИЙ ЗАМЫН ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ БҮТЭЭГДЭХҮҮН**

BILBERRY

№60 КАПСУЛ

Хүний нүдний эрүүл байдал, харааг хамгаалах болон цусны эргэлтийг дэмжих үйлдэл бүхий байгалийн гаралтай хүчирхэг антиоксидант буюу эсийн хэт исэлдэлтийн эсрэг бүтээгдэхүүн.

НЭРС ЖИМСНИЙ АЧ ТУС:

- » Судас, цусны эмгэг, судас бөглөрөл, гүйлсэн булчирхайн эмгэг зэрэг өвчний эмчилгээнд хэрэглэдэг.
- » Өдөр бүр 1 нэрсний ханд уухад түүнд агуулагдах антоцианин нь цусны даралтыг бууруулж, тархи, мэдрэлийн цусан хангамжийг сайжруулж, цус бүлэгнэлтийг бууруулах ач тустай.
- » Чихрийн шижин өвчтэй хүмүүс нэрсийг хүнсэндээ хэрэглэснээр цусны сахар тогтворжино. Учир нь нэрсэнд агуулагдах гликоконин хэмээх бодис нь цусны сахрыг бууруулах үйлчлэл үзүүлдэг.
- » Нэрс нь таны биеэс хорт бодисыг гадагшлуулдаг тул залуу насаа хадгалах гол зэвсэг тань болж чадна. Нэрсэнд антиоксидант С, А аминдэм агуулагдах учир эсийн чөлөөт радикалын гэмтлээс сэрийдэг.
- » Нэрсийг тогтмол хэрэглэх нь нүдний торлог бүрхэвчний эмгэг, нүдний даралт, холын харалган, ажлаас болон хиймэл гэрлийн нөлөөнөөс үүссэн ядаргааг тайлж, нойргүйдлийг намжаана.

НАЙРЛАГА:

- Нэрсний ханд – 27.5мг



ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

Насанд хүрэгчид: Өдөрт 1 капсулыг ууна.

НҮДНИЙ ХАРААГ САЙЖРУУЛАХ БҮТЭЭГДЭХҮҮН

LUTEIN GUMMIES

№60 ГАММИС

Нүдний эрүүл мэндийг дэмжинэ. Лютейн нь ногоон навчит ургамалд ихээр агуулагддаг бөгөөд нүдний эрүүл мэндэд нэн чухал нөлөөтэй бодис юм. Лютейн нь нүдний ядралт, нүдний шар толбоны (macula) бүтцийн өөрчлөлт болон хараа алдалтаас сэргийлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Өдөр тутамд багадаа 10мг лютейн хэрэглэснээр нүдний шар толбоны гэмтэл үүсэхээс сэргийлэх боломжтой. Лютейн болон Зеаксантин нь нарны туяанаас шалтгаалж үүсэх нүдний гэмтлийг бууруулдаг гэж эрдэмтэд үзэж байна. Зарим судалгааны үр дүнгээр уг бодис нь насжилтын шалтгаант катаракт үүсэлтэйг мөн бууруулдаг нь тогтоогджээ.

НАЙРЛАГА: Нэг гаммисд:

- » Лютейн – 10мг,
- » Нэрсний ханд – 25мг,
- » Зеаксантин – 500мг

ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

Насанд хүрэгчид: Өөх эсвэл тос агуулсан хоолтой хамт өдөрт 2ш гаммис зажилж хэрэглэнэ.



НҮДНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ БҮТЭЭГДЭХҮҮН

GOLLAGEN

№60 КАПЛЕТ

Үрчлээний эсрэг коллаген нь арьсны үндсэн хоёр давхаргыг (эпидерми ба дермис) гидролизжсэн коллагенаар хангаснаар 28 хоногийн дотор нарийн үрчлээ болон ердийн үрчлээг багасгаж арьсыг илүү чанга, залуу харагдуулдаг нь эмнэл зүйн судалгаагаар батлагдсан.

ҮРЧЛЭЭНИЙ ЭСРЭГ КОЛЛАГЕНЫ ДАВУУ ТАЛ:

Коллаген бол хүний биед хамгийн их агуулагддаг уураг бөгөөд уургийн найрлагын гуравны нэгийг бүрдүүлдэг. Мөн яс, арьс, булчин, холбогч эд, шөрмөсөнд агуулагдаж байдгаас гадна цус, эвэрлэг бүрхэвч, шүд зэрэг биеийн бусад хэсгүүдэд ч бас оршиж байдаг.

- » 28 хоногт нарийн үрчлээ болон ердийн үрчлээг багасгана.
- » Хөгшрөлтөөс сэргийлж, суларсан арьсыг чангална.
- » Артерийн судасны хатуурал, даралт ихсэхээс сэргийлнэ.
- » Үе мөчний залуу байдлыг хадгалж, ясны зөөлөн эд үрэгдэж элэгдэхийг багасгадаг.
- » Үс, хумсыг бэхжүүлэн, хугарч гэмтэхийг багасган эрүүл ургалтыг дэмжинэ.

НАЙРЛАГА:

Гидролизжсэн коллаген - 1 каплет бүрд 833,34 мг



ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

Насанд хүрэгчид: Өдөрт 3 каплет хэрэглэнэ.

АНХААРУУЛГА:

Жирэмсэн болон хөхүүл эхчүүд хэрэглэхээс өмнө эмчтэй зөвлөнө үү. Ходоод гэдэсний бага зэрэг зовуурь үүсгэж болзошгүйг анхаарна уу.

**ХӨГШРӨЛТИЙН ШИНЖ ТЭМДГИЙГ БАГАСГАЖ,
АРЬСНЫ ӨНГӨ ТӨРХИЙГ СЭРГЭЭХ БҮТЭЭГДЭХҮҮН**

CLEAR SKIN

№60

ЗӨӨЛӨН ГЕЛЬ

Арьсны улайлт, батгатай холбоотой үрэвслийг багасган арьсийг эрүүл байлгахад туслан арьсний өнгийг сэргээнэ. Арьсны өнгийг сайжруулж, батганы шалтгаант үрэвслийг багасгахад тусална.

НАЙРЛАГА: Нэг зөөлөн гельд:

- » Боржийн тос - 670 мг,
- » Чацаргана - 50 мг,
- » Част ургамлын ханд-5 мг,
- » Витамин А - 300 мкг,
- » Биотин-150 мкг,
- » Витамин Е - 3 мг,
- » Хром - 60 мкг,
- » Цайр - 5 мг

ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

Насанд хүрэгчид: Өдөрт 3 ширхэг зөөлөн гелийг хоолны үеэр ууна. Бусад эм, байгалийн гаралтай эрүүл мэндийн бүтээгдэхүүнийг хэрэглэхээс өмнө эсвэл хэдэн цагийн дараа ууна. Сайн үр дүнг харахын тулд хамгийн багадаа хаяж 3 сар хэрэглэнэ.

АНХААРУУЛГА:

Хэрэв шинж тэмдгүүд арилахгүй эсвэл муудаж байвал, эсвэл прогестерон бэлдмэл, жирэмслэлтээс хамгаалах бэлдмэл эсвэл дааврын орлуулах эмчилгээ зэрэг даавар агуулсан эм хэрэглэж байгаа бол хэрэглэхийн өмнө эмчээс зөвлөгөө аваарай.



**АРЬСНЫ ӨНГИЙГ СЭРГЭЭЖ, БАТГАНЫ ШАЛТГААНТ
ҮРЭВСЛИЙГ НАМДААХ БҮТЭЭГДЭХҮҮН**

GORGEOUS HAIR

№60

ЗӨӨЛӨН ГЕЛЬ

Илүү бат бэх, өтгөн үстэй болоход дэмжлэг үзүүлнэ. Jamieson Gorgeous Hair нь байгалийн гаралтай гоо сайхны хүчирхэг хоёр найрлагыг хослуулсан: биотин ба органик, кокосын тос агуулсан. Тэд хамтдаа үсний ургалтыг дэмжиж, илүү бат бөх, эрүүл харагдах үсийг дэмжиж тэжээлээр хангадаг.

- » Илүү бат бөх, өтгөн, эрүүл үс
- » Гэмтэл хугарлыг багасгах

НАЙРЛАГА: Нэг зөөлөн гельд:

- » Биотин (*Biotin*) – 10.000 mcg,
- » Органик кокосын тос (*Organic Extra-Virgin Coconut Oil*) – 500mg

ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

Насанд хүрэгчид: Өдөрт 1 зөөлөн гель ууна. 1 сараас дээш хугацаагаар хэрэглэхийн тулд эмчээс зөвлөгөө аваарай.



АНХААРУУЛГА:

Хэрэв та жирэмсэн эсвэл хөхүүл бол хэрэглэхээсээ өмнө эмчээс зөвлөгөө аваарай. Биотины нэмэлтүүд нь эмнэлгийн лабораторийн шинжилгээнд саад учруулж болзошгүй; Хэрэв та энэ бүтээгдэхүүнийг хэрэглэж байгаа бол эмчээс зөвлөгөө аваарай.

**ҮСНИЙ ГЭМТЭЛ ХУГАРЛЫГ БАГАСГАЖ, ҮСИЙГ
БАТ БӨХ БОЛГОХ БҮТЭЭГДЭХҮҮН**

HAIR SKIN NAILS

№45 ЗАЖИЛДАГ ШАХМАЛ

Зөвхөн насанд хүрэгсдэд зориулсан үс, хумс, салст бүрхэвч болон арьсыг эрүүл байлгах, арьсны гоо сайхныг дэмжинэ.

НАЙРЛАГА:

Амин дэм: Витамин А - 500 мкг, Витамин В1 - 2 мг, Витамин В2 - 2 мг, Витамин В3 – 8мг, Витамин В5 - 5 мг, Витамин В6 - 2 мг, Витамин В12 -3 мкг, Витамин С - 40 мг, Витамин Д3 -5 мкг/200 ОУН, Витамин Е - 5 мг, Биотин-2,500 мкг, Фолийн хүчил - 65 мкг;

Эрдэс бодис: Кальци - 150 мг, Төмөр - 1 мг, Магни- 35 мг, Манган- 2 мг, селен - 5 мкг, Цайр- 2.5 мг;

Тэжээллэг бодис: Альфа липоидын хүчил-5 мг, холин -25 мг, лютеин- 5 мг, шар буурцаг- 57.5 мг, 40% хүртэлх шар буурцгийн изофлавоноуд-23 мг, нийт изофлавоноуд - 12 мг

ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

Насанд хүрэгчид: Өдөрт 1 каплетыг хоолны хамт ууна. Бусад эм, байгалийн гаралтай эрүүл мэндийн бүтээгдэхүүнийг хэрэглэхээс өмнө эсвэл хэдэн цагийн дараа ууна. 1 сараас дээш хугацаагаар хэрэглэх бол эмчээс зөвлөгөө аваарай.

АНХААРУУЛГА:

Хэрэв та жирэмсэн эсвэл хөхүүл бол; чихрийн шижин, элэгний эмгэг эсвэл элэгтэй холбоотой өвчний шинж тэмдгүүд (жишээлбэл, хэвлийгээр өвдөх, элэгний шарлалт, шээс хөөх) үүсэх; бамбай булчирхайн даавар орлуулах эмчилгээ хийлгэж байгаа бол хэрэглэхийн өмнө эмчээс зөвлөгөө аваарай. Биотины нэмэлтүүд нь эмнэлгийн лабораторийн шинжилгээнд саад учруулж болзошгүй; Хэрэв та энэ бүтээгдэхүүнийг хэрэглэж байгаа бол эмчээс зөвлөгөө аваарай. Хэт мэдрэг байдал үүсвэл хэрэглэхээ зогсоо.



**ҮС, АРС, ХУМСНЫ ЭРҮҮЛ БАТ БӨХ БАЙДЛЫГ
ДЭМЖИХ БҮТЭЭГДЭХҮҮН**

ECHINACEA TINCTURE

50 МЛ, ШИНГЭН ДУСАЛ

Амьсгалын дээд замын халдвар болон ханиадтай тэмцэхэд тусална. Амьсгалын дээд замын халдвар нь вирусээр үүсгэгддэг амьсгалын замын халдварт өвчин юм. Энэхүү өндөр үр дүнтэй, шингэн хэлбэрийн Эхинацеи ханд нь амьсгалын дээд замын халдварын шинж тэмдгийг бууруулах, үргэлжлэх хугацааг богиносгоход тустай.

НАЙРЛАГА: Нэг удаагийн хэрэглээнд (2 мл):

- » *Echinacea* (2:1) extract 1,000 mg;
- » (*Echinacea purpurea*, ургамалын дээд хэсэг) 2000 мг ургамалтай тэнцэнэ.

ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

Насанд хүрэгчид: Халдварын эхний шинж тэмдэг илэрвэл ууна. Өдөрт 3 удаа 40 дусал буюу 2 мл-ийг бага зэрэг усанд эсвэл шууд ууна. 2 сараас дээш хугацаагаар хэрэглэхийн тулд эмчээс зөвлөгөө аваарай.



АНХААРУУЛГА:

Хэрэв шинж тэмдгүүд арилахгүй, муудаж байвал, эсвэл хэрэглэхийн өмнө дараах тохиолдолд эмчээс зөвлөгөө аваарай: Хэрэв та аутоиммун эмгэгтэй эсвэл сүрьеэ, коллагеноз, удаа дараагийн склероз, ДОХ ба/эсвэл ХДХВ-ийн халдварт өвчинтэй; дархлаа дарангуйлагч эм ууж байгаа бол. Хүнд хэлбэрийн харшлын урвалын ховор тохиолдол илэрсэн, Daisy овгийн ургамалд харшилтай бол болгоомжтой хэрэглээрэй.

АМЬСГАЛЫН ЗАМЫН ХАЛДВАРААС
СЭРГИЙЛЭХ БҮТЭЭГДЭХҮҮН

GLUCOSAMINE CHONDROITIN

900 МГ №125 КАПЛЕТ

Энэхүү үе мөчний бүтээгдэхүүн нь яс, мөгөөрсөн эд, шөрмөс, үений шингэний хэвийн байх нөхцөлийг хангаж, гэмтсэн үе мөч, мөгөөрсийг нөхөн сэргээж, үе мөчний өвдөлтийг намдаахад тусална.

НАЙРЛАГА:

- » Глюкозамины сульфат- 500 мг
- » Хондроитин сульфат - 400 мг

ХЭРЭГЛЭХ ЗААЛТ:

- » Үе мөч, мөгөөрсийг эрүүл байдал
- » Остеоартриттай холбоотой үе мөчний өвдөлтийг намдаахад тусална

ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

Насанд хүрэгчид: 1 бүрмэл бэлдмэлийг хоногт 3 удаа хооллох үедээ ууж хэрэглэнэ. Эерэг үр дүнг мэдрэхийн тулд хамгийн багадаа 1 сарын турш хэрэглээрэй.

АНХААРУУЛГА:

Зөвхөн насанд хүрсэн хүмүүст зориулсан. Найрлагын жагсаалт дах аль нэг нэгдэлд харшилтай бол хэрэглэж болохгүй. Хэрэв ямар нэгэн эмийн бэлдмэл хэрэглэж байгаа, эсвэл эмчийн хяналтад байдаг эсвэл жирэмсэн, жирэмсэн болохоор төлөвлөж байгаа, хөхүүл эх, мөн нэмэлтээр дээрх аминдэм болон эрдэс бодис хэрэглэх тохиолдолд хэрэглэхийн өмнө өөрийн эмчээсээ зөвлөгөө авна уу. Хүүхдийн гар хүрэхгүй газар хадгална уу.



**ҮЕ МӨЧ, МӨГӨӨРСӨН ЭДИЙН ХЭВИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ БҮТЭЭГДЭХҮҮН**

RESVERATROL

№30 КАПСУЛ

Антиоксидантуудын эх үүсвэр тул зүрх судасны эрүүл мэндийг дэмжинэ. Өвөрмөц найрлага бүхий дээрх иж бүрдэл нь чөлөөт радикалуудын түрэмгий нөлөөг арилгаж, дархлааны тогтолцоо болон зүрх судасны хэвийн үйл ажиллагааг дэмжинэ.

Jamieson Resveratrol нь Европын усан үзмийн үрээр баяжуулсан улаан дарсны хандны хүчтэй хольц бөгөөд хүчтэй антиоксидант үйлчилгээ үзүүлдэг.

НАЙРЛАГА:

- » Resveravine® усан үзмийн ханд (*Vitis vinifera, vine*)-50 мг
- » Транс-ресвератрол - 3 мг
- » Leucoselect Phytosome® Олигомер усан үзмийн үрийн проантоцианидин ба фосфатидилхолины иж бүрдэл (*Vitis vinifera seed; Glycine max, seed*) 8.25мг хүртэл
- » Хэмжээт олигомерийн проантоцианидин-100 мг.

ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

Насанд хүрэгчид: 1 капсулыг өдөрт 1-3 удаа ууна. 1 сараас дээш хугацаагаар хэрэглэхийн тулд эмчээс зөвлөгөө аваарай.



АНХААРУУЛГА:

Хэрэв та жирэмсэн эсвэл хөхүүл бол; жортой эм ууж байгаа бол ресвератрол нь эмийн үйлчилгээнд нөлөөлж болзошгүй тул хэрэглэхийн өмнө эмчээс зөвлөгөө аваарай.

**ЗҮРХ СУДАСНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙГ
ДЭМЖИХ БҮТЭЭГДЭХҮҮН**

CHEWABLE C 500 MG NATURAL TANGY ORANGE

№100+20ш

ЗАЖИЛДАГ ШАХМАЛ

C-Аминдэмийн нэмэлт эх үүсвэр буюу тэдгээрийн дутлаас сэргийлэх антиоксидант үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийг дэмжигч бүтээгдэхүүн. C -Аминдэм нь бие махбодийн дархлааны системийг хэвийн үйл ажиллагааг дэмжиж, ядаргаа болон сульдааг бууруулах, бодисын солилцоог зохицуулах, яс, мөгөөрс, шүд, буйлны болон арьсны хэвийн үйл ажиллагааг хангахад тустай.

ВИТАМИН С АЧ ТУС:

- » Эсийг хамгаалж, эрүүл байлгахад тусалдаг
- » Арьс, судас, яс, мөгөөрсийг эрүүл байлгах
- » Шархыг эдгээхэд тусалдаг

НАЙРЛАГА:

C - Аминдэм (Ascorbic acid, Sodium ascorbate) - 500 мг;

ХЭРЭГЛЭХ ЗААЛТ:

- » Буйл хавагнах цус гарах
- » Үс хугарч унах, гэмтэх
- » Дархлаа муудах
- » Арьс хуурайших, гэмтэх, үрчлээ тогтох, арьсны шарх эдгэрэлт удаашрах
- » Хамраас цус гоожих
- » Хумс хэврэгших
- » Ядрах, сульдах
- » Ургамлын гаралтай төмөр шингээлт муудах, төмөр дутлын цус багадалт

ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

4-8 насны хүүхэд: өдөрт нэг шахмалыг,

9-13 насны хүүхэд: өдөрт 1-2 шахмалыг,

14-18 өсвөр насанд: өдөрт 1-3 шахмалыг,

Насанд хүрэгсэд: өдөрт 1-4 шахмалыг зажилж хэрэглэнэ.



ДАРХЛААНЫ СИСТЕМИЙН ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ БҮТЭЭГДЭХҮҮН



JamiesonTM
NATURAL SOURCES | SINCE 1922

**БҮТЭЭГДЭХҮҮНИЙ
ТАНИЛЦУУЛГА**



**ГЭР БҮЛИЙН
ГИШҮҮН БҮРД**

essenti  **ls**
TM/MC